



**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх” гэж заасан.

Үүний дагуу ЗГ-ын 2022 оны 80 дугаар тогтоолын хүрээнд ашигт малтмал, газрын тосноос бусад салбарын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлж ирсэн. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан, мөн “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн үйлчлэх хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсонтой тус тус холбогдуулан тус зохицуулалтыг уг хуульд тусгаж, 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Мөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ийг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлохдоо Боомт, Эрчим хүч, Аж үйлдвэр, Хот, хөдөө, Ногоон хөгжил, Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого, зорилтын хүрээнд туссан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дотоодоос хангах бололцоогүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломжийг бүрдүүлсэн байхаар туссан.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Монгол Улсын эдийн засаг тэлж, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа өргөжих, хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, ажиллах хүчний хомсдол бий болж байгаатай холбогдуулан ажиллах хүчийг гадаадаас авахад баримталж байгаа бодлогыг өөрчлөх, ажлын байрны төлбөрийн хэмжээг бууруулах, хөнгөлөлт, чөлөөлөлтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх шаардлага үүсч байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 онд хийсэн “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны үр дүнгээс үзэхэд 2022 онд аж ахуйн нэгж, байгууллагуудын 15.9 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажил олгогчдын 42.7 мянган ажлын байранд ажиллах хүн олдоогүй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өссөн үзүүлэлт юм.

Ажиллах хүчний хомсдол ихээр үүсэж байгаа эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудыг авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа: машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт 22.5%, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 14.3%, барилгын салбарт 13.2%, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 11.7% хомсдол тус тус үүсээд байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого, улс орны хэмжээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд 2025 он хүртэл нийт 285.0 мянган ажлын байр бий болох урьдчилсан тооцоолол гарснаас 140.0 гаруй мянга нь бүтээн байгуулалтын үед буюу ойрын хугацаанд бий болохоор байна.

Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гадаадад оршин суугаа иргэн 122301 байгааг Үндэсний статистикийн хороо албан ёсоор танилцуулсан хэдий ч албан бус тоогоор 196.4 мянган иргэн хилийн чанадад амьдарч байгаа нь дотоодод ажиллах хүчний хомсдол бий болох нэгэн гол шалтгаан болж байна.

Гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаанд оршин суугаа Монгол Улсын хүн амыг оршин сууж байгаа улсаар хувьчилж авч үзвэл: БНСУ 32.7 хувь, АНУ 15.7 хувь, Япон Улс 7.2 хувь, Казахстан 5.9 хувь, Чех Улс 4.9 хувь, Австрали 4.5 хувь, БНХАУ 4.2 хувь тус тус байна. Мөн гадаадын зарим улс орнууд Монгол Улсаас авах ажиллах хүчний квот, хувь хэмжээг нэмэгдүүлж байгаа нь иргэд гадаад улсад хөдөлмөр эрхлэх сонирхлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, БНСУ манай улсаас 2022 онд 855 ажилтан авахаар квот тогтоож байсан бол 2023 онд 2804 хүн болгож өсгөсөн. Чех Улс 2022 онд 1000 хүний квот тогтоож байсан бол 2023 онд 3000 хүн болгож өсгөсөн байна.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулж, ойрын хугацаанд ажиллах хүчний хомсдолыг нөхөх зорилгоор гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлага үүсч байна.

Түүнчлэн дэлхийн улс орнуудад ажиллах хүчний хомсдол үүсч байгаатай холбогдуулан улс орон бүр ажиллах хүч гаднаас авах уян хатан зохицуулалтуудыг авч хэрэгжүүлж байна. Манай Улсын тухайд хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилтын тоо, хувь хэмжээ 2012 онтой харьцуулахад 3 дахин багассан байна.

Үүний голлох шалтгаан нь аж ахуйн нэгж, байгууллагуудын төлж буй гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хувь хэмжээ бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр төлбөр төлж байгаа нь ихээхэн дарамт болж байгаа талаар ажил олгогчдын зүгээс илэрхийлсээр байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшний өөрчлөлт, хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн зохистой харьцаа, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээ, эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, инфляцын түвшинг харгалзан Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо 2 жил тутам тогтоохоор заасан.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үеийн нөхцөл байдлыг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоогоогүй бөгөөд 2023 онд 550.000 төгрөг, 2024 онд 660.000 төгрөг болгож шинэчлэн тогтоосон.

Мөн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороонд төлөөлөл бүхий аль нэг тал нь санал гаргасан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өөрчилж болохоор зохицуулалттай учир цаашид нэмэгдүүлэх хүсэлтийг ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөллөөс тогтмол тавьж байна.

Цаашид хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж тогтоохгүй байх бодлогыг баримталж байгаа болно. Иймд гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтоож байх зохицуулалтыг бий болгох шаардлага байна.

Мөн Төсвийн тухай хуульд ирэх оны төсвийг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлахаар заасны дагуу бүтээн байгуулалтад шаардагдах төсөв нь батлагдсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийн холбогдох тооцоо, судалгаанд тулгуурлан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох хэрэгцээ, шаардлагатай байна.

Түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоодоос ажиллах хүчний хомсдол үүсч байгаа болон ажлын байрны төлбөрийг бууруулах тухай санал хүсэлтүүдэд үндэслэн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотой асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан.

Иймд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монголд зочлох жил” болон бусад бодлого, зорилтын хүрээнд бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд, бусад аж ахуйн нэгжийг дэмжих хүрээнд дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад гарч буй өөрчлөлтийг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах зохицуулалтыг тусгана:

- ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох;

- гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтоох;

- гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудал нь цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байгаа тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар гадаад ажилтан авч ажиллуулах ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчид төрд төлөх ажлын байрны төлбөрөөс хөнгөлүүлж, чөлөөлөгдөж, бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд 2024 оны улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй болно.

Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлого нь төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж буй салбараас хамааран тодорхой хэмжээгээр буурах хэдий ч ашигт малтмал, газрын тосны салбарын орлого нь нийт орлогын 50 хүртэлх хувийг бүрдүүлж байгаа учир төсөвт төдийлөн нөлөө үзүүлэхээргүй байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн тухай

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.